*ТА **ИНТЕРНЕТ БАНК** БОЛОН **319708, 319709** УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.*

**2022.02.16**

| Валют | Ханш | 24ц өөрч. |
|---|---|---|
| EUR/USD | 1.1355 | -0.04% |
| USD/CNY | 6.3389 | 0.06% |
| USD/RUB | 75.3665 | 0.02% |
| USD/JPY | 115.71 | 0.09% |
| USD/KRW | 1197 | -0.25% |
| AUD/USD | 0.7152 | -0.07% |
| GBP/USD | 1.3546 | 0.00% |
| **Индекс** | **Нэгж** | **24ц өөрч.** |
| Dow Jones | 34988.8 | 1.22% |
| S&P 500 | 4471.1 | 1.58% |
| NASDAQ | 14139.8 | 2.53% |
| FTSE 100 | 7608.9 | 1.03% |
| Nikkei 225 | 27368.3 | 1.87% |
| DAX | 15412.7 | 1.98% |
| Hang Seng | 24355.7 | -0.82% |
| **Метал** | **Ханш (USD)** | **24ц өөрч.** |
| Алт | 1851.01 | -0.14% |
| Мөнгө | 23.30 | -0.27% |
| Нүүрс (Чин хуанг дао) | 166.43 | #VALUE! |
| Зэс (LME) | 9968.5 | 0.49% |
| Төмрийн хүдэр | 708.50 | -2.68% |
| Газрын тос (NYME) | 92.32 | 0.27% |
| **LIBOR** | **Хүү** | **24ц өөрч.** |
| US 1M LIBOR | 0.13% | -34.23% |
| US 3M LIBOR | 0.46% | -9.45% |
| US 6M LIBOR | 0.79% | -5.54% |
| US 12M LIBOR | 1.32% | -5.04% |
| **Бонд** | **Хүү** | **24ц өөрч.** |
| US Treasury 10Y | 2.03% | -0.43% |
| UK Treasury 10Y | 1.58% | -0.44% |
| GE Treasury 10Y | 0.31% | 8.83% |
| JP Treasury 10Y | 0.22% | -1.83% |

| Бонд (Монгол) | Хүү | Дуусах огноо | Өгөөж | 24ц өөрч. |
|---|---|---|---|---|
| Чингис | 5.13% | 12/5/2022 | 3.10% | 0.08% |
| Гэрэгэ | 5.63% | 5/1/2023 | 3.41% | 0.00% |
| МУХБ 2023 | 7.25% | 10/23/2023 | 4.26% | -0.05% |
| Хуралдай | 8.75% | 3/9/2024 | 4.01% | -0.05% |
| ММС | 9.25% | 4/15/2024 | 24.00% | -1.82% |
| МИК 2024 | 8.85% | 8/2/2024 | 11.24% | -0.03% |
| Номад | 5.13% | 4/7/2026 | 4.74% | -0.04% |
| Монгол 27 | 3.50% | 7/7/2027 | 4.98% | -0.05% |
| Монгол 31 | 4.45% | 7/7/2031 | 5.40% | -0.17% |
| Самурай JPY | 1.52% | 12/25/2023 | 0.03% | 0.00% |

## Онцлох мэдээ

- Эдийн засагчдын дундах Ройтерсийн санал асуулгаар АНУ-ын Холбооны Нөөцийн банк 3-р сараас эхлэн бодлогоо чангатгаж, хүүг 25 суурь нэгжээр өсгөнө гэсэн бол 50 суурь нэгж буюу илүү эрчтэй хөдөлнө гэсэн цөөнх нэмэгдсээр байна.
- Эмнэлгийн амбулаторийн эмчилгээний зардал, хүнс болон моторт тээврийн хэрэгсэл зэрэг бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт дунд АНУ-ын үйлдвэрлэгчийн үнэ сүүлийн 8 сарын хугацаанд хамгийн ихээр өсжээ. Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) 12-р сард 0.4% өссөний дараа 1-р сард 1.0% өслөө.

## Валютын зах зээл

ОХУ зарим цэргээ Украйны хилийн ойролцоогоос буцаан татсан тухай мэдээ гарснаар евро өнөөдрийн Азийн эхэн үеийн арилжаагаар өнгөрсөн шөнө өссөн өсөлтөө тогтоон барилаа. Гэхдээ хурцадмал байдал хэвээр байж нийтлэг валютууд ахиц гаргаж чадсангүй. Өмнөх арилжааны өдөр 0.45% үсэрсэн еврогийн ханш өнөөдөр тогтуун байна. Эсрэгээр Даваа гарагт цухасхан 114.99 хүрээд байсан эрсдэл багатай иен бага зэрэг суларч хамгийн сүүлд 115.65-р арилжаалагдлаа. Хүүг өсгөх хандлага фунтийн ханшинд дэмжлэг болж 1.3543-д хүрчээ. Өнгөрсөн шөнө Австрали доллар 0.35%, Шинэ Зеланд доллар 0.4% өсөөд байсан бол өнөөдөр тус хоёр валют харгалзан 0.7146; 0.6639-р арилжаалагдаж байна.

## Алтны зах зээл

Лхагва гарагт алтны ханш ухарлаа. Өмнөх арилжааны өдөр 8 сарын дээд цэгтээ хүрээд байсан бол Орос Украйны зөрчилдөөн намжсанаар эрсдэл багатай алтны эрэлт буурсаар байна. Өглөөний байдлаар 1 унц алтны спот ханш 0.1% бууралттай 1,850.91 ам.доллар байсан бол АНУ-ын алтны фьючерс GCv1 0.2% уналттай 1,852.40 ам.доллар хүрээд байна.

## Зэсийн зах зээл

ОХУ зарим цэргээ Украйны хилийн ойролцоох бэлтгэл сургуулилтаасаа бааз руугаа татсанаар болзошгүй халдлагын айдсыг намжааж, санхүүгийн зах зээлийг дэмжсэнээр өчигдөр зэсийн үнэ өсөв. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс Даваа гарагт 0.6% нэмэгдсэний дараа Мягмар гарагт 0.5% өсөж 9,965 ам.долларт хаагджээ. Таваарын Бирж (COMEX) дээрх зэс 0.6% өсөж фунт нь 4.54 ам.доллар хүрсэн байна.

Хятадын томоохон хайлуулах үйлдвэрүүдийн зэсийн катодын гарц 1-р сард өмнөх сараас 7.49% буурсныг Антайке судалгааны байгууллагаас мэдээлсэн бөгөөд засвар болон баярын амралт зэрэг нөлөөлжээ. Тодруулбал,

| Хувьцаа | Ханш | 24ц өөрч. |
|---|---|---|
| Turquoise Hill Resources | 21.11 | 3.23% |
| Mongolian Mining Corp | 2.01 | 0.50% |
| Erdene Resource Dev | 0.44 | 1.15% |
| Centerra Gold | 10.93 | 0.46% |

| Макро эдийн засаг (Монгол) | Огноо | Дүн |
|---|---|---|
| Инфляцийн түвшин | 2022 (I) | 14.6% |
| Бодлогын хүү | 2022 (I) | 6.5% |
| Банк хоорондын зах зээлийн хүү | 2021 (XI) | 6.08% |
| Хадгаламжийн дундаж хүү (төг) | 2021 (XII) | 7.04% |
| Хадгаламжийн дундаж хүү (валют) | 2021 (XII) | 2.04% |
| Зээлийн дундаж хүү (төг) | 2021 (XII) | 15.54% |
| Зээлийн дундаж хүү (валют) | 2021 (XII) | 9.07% |

**Ханшийн таамаглал**

| Валют | Q1 22 | Q2 22 | Q3 22 | Q4 22 | 2023 |
|---|---|---|---|---|---|
| EUR/USD | 1.12 | 1.13 | 1.15 | 1.15 | 1.17 |
| GBP/USD | 1.34 | 1.35 | 1.36 | 1.37 | 1.40 |
| USD/CNH | 6.39 | 6.35 | 6.40 | 6.44 | 6.40 |
| USD/JPY | 114 | 115 | 115 | 115 | 115 |
| USD/RUB | 73.0 | 72.0 | 73.07 | 73.0 | 73.5 |
| **Түүхий эд** | | | | | |
| Алт | 1775 | 1750 | 1700 | 1680 | 1650 |
| Зэс | 9500 | 9350 | 9400 | 9500 | 9550 |
| Нүүрс | 138.13 | 109.38 | 93.13 | 79.38 | 62.50 |

*эх сурвалж: Блүүмбэрг*

**Эдийн засгийн голлох тоо мэдээ**

| Өмнөх өдрийн үр дүн | Үр дүн | Таам. | Өмнөх |
|---|---|---|---|
| GE ZEW Current Conditions | -8.1 | -7.0 | -10.2 |
| GE ZEW Economic Sentiment | 54.3 | 53.5 | 51.7 |
| UK ILO Unemployment Rate | 4.1% | 4.1% | 4.1% |
| JP GDP QQ Annualized | 5.4% | 5.8% | -3.6% |
| JP GDP QQ | 1.3% | 1.4% | -0.9% |

| Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ | Цаг | Таам. | Өмнөх |
|---|---|---|---|
| US Retail Sales MM | 21:30 | 2.0% | -1.9% |
| US Industrial Production MM | 22:15 | 0.4% | -0.1% |
| UK CPI YY | 15:00 | 5.4% | 5.4% |
| CN CPI YY | 9:30 | 1.0% | 1.5% |
| CN PPI YY | 9:30 | 9.5% | 10.3% |

| Маргааш хүлээгдэж буй мэдээ | Цаг | Таам. | Өмнөх |
|---|---|---|---|
| JP Trade Balance Total Yen | 7:50 | -1607B | -582.4B |
| JP Imports YY | 7:50 | 37.1% | 41.1% |
| JP Exports YY | 7:50 | 16.5% | 17.5% |
| JP Machinery Orders YY | 7:50 | 0.6% | 11.6% |
| JP Machinery Orders MM | 7:50 | -1.8% | 3.4% |

нийт хүчин чадлын 83 орчим хувийг илэрхийлдэг 22 хайлуулагчдын гарц 802,200 тонноос 742,100 тонн болж буурчээ.

## Газрын тосны зах зээл

ОХУ зарим цэргээ хил орчмоос татаж эхэлснээр газрын тосны үнэ суларлаа. Өчигдөр 3 хувь сулраад байсан ч өнөөдөр бага зэрэг өссөн байна. ХБНГУ болон ОХУ нарын тэргүүнүүдийн уулзалт ОХУ дипломат харилцаа тогтооход нөлөөлсөн байж магадгүй байна.

## Бондын зах зээл

Мягмар гарагт АНУ-ын засгийн бондууд хугацаагаараа ялгаатай өндөрлөлөө. Арилжааны өдрийн сүүлээр байгууллагуудын бонд гаргах шинэ хуваарь ачаалал ихтэй гарснаар урт хугацааны бонд буурсан байна. АНУ-ын цагаар үдээс хойш 30 жилийн хугацаатай өгөөж 2.36% давсан бөгөөд 5 сараас хойших хамгийн хямд түвшинд очлоо. Хувьцааны зах 1-2 хувийн өсөлтөө барьсаар байгаа нь Засгийн бондод дарамт болж өгсөн бөгөөд, геополитикийн зөрчилдөөн намжиж байгаа гэсэн таамгаас шалтгаалсан юм. Үүний сацуу Лхагва гарагт зарлагдах 20 жилийн хугацаатай 19 тэрбум ам.долларын дуудлага худалдаа зах зээлийн хөдөлгөөнд нөлөөлсөн байна.

## Хөрөнгийн зах зээл

БНХАУ-ын инфляцийн мэдээ таамаглалаас бага гарч мөнгөний зөөлөн бодлого явуулах орон зай гарснаар Азийн хөрөнгийн зах зээл өсөлттэй байна. ОХУ хил орчмоос зарим цэргээ татсанаар геополитикийн эрсдэл буурч хөрөнгийн зах зээл өсөлт үзүүлсэн. Тухайлбал технологийн компаниудын үнэ өсөж S&P500 индекс дараалсан уналтаа зогсоосон ч өнөөдөр бага зэрэг уналттай арилжаалагдаж байна.

*Мэдэгдэл*

*Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт хариуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мейлд хариу илгээнэ үү.*